



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/007/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

аудитор: Д.Мөнхтулга

Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.03.25 № 2/2025

танай _____ -ны № _____ -Т

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.ХАТАНБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын захиалагчийн хяналтын зардлыг суутгаагүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өмнөх онуудад гэрээ байгуулж 248,629.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан ч ажлаа хийгээгүй аж ахуйн нэгжүүдээс авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй
- Тайлант онд ижил нэршилтэй арга хэмжээнүүдийг дугаарлаж босго үнээс бууруулж 134,586.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулж худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас зайлсхийсэн.
- Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг ялгаатай тогтоож олгосон.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүргийг хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах" гэсэн заалтуудыг мөрдөөгүй иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Алтай сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 798,089.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 178,900.9 мянган төгрөгөөр буюу 28.9 хувиар давуулан биелүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,428,511.40	1,553,091.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	538,242.10	681,969.60
33	АВЛАГА	282,243.20	190,510.70
34	УРЬДЧИЛГАА	461,488.10	475,490.70
35	БАРАА МАТЕРИАЛ	146,538.10	205,120.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,014,382.00	5,229,249.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,014,382.00	5,229,249.30
39200	Биет хөрөнгө	4,010,022.60	5,225,249.30
39300	Биет бус хөрөнгө	4,359.40	4,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,442,893.40	6,782,341.10
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	818.9	78,054.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	818.9	78,054.60
41300	Өглөг	818.9	78,054.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,442,074.50	6,704,286.50
51	Засгийн газрын хувь оролцоо	5,442,074.50	6,704,286.50
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,034,383.70	1,034,383.70
51200	Хуримтлагдсан үр дүн	3,829,268.40	5,091,480.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	578,422.40	578,422.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,442,893.40	6,782,341.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,827,932.00	5,418,781.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	419,924.50	779,910.90
110	Орлогын албан татвар	302,812.10	670,065.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	321,305.00	688,180.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-18,492.80	-18,114.80
113	Хөрөнгийн албан татвар	32,799.50	41,014.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	84,312.80	68,831.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	409,171.40	1,503,479.00
120	Нийтлэг татварын бус орлого	409,171.40	1,503,479.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,998,836.10	3,135,391.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,413,654.80	4,156,569.40

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,413,654.80	4,156,569.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,413,263.80	4,100,025.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,396.30	771,875.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,229.80	96,355.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,172.10	656,918.40
2104	Хангамж, бараа материалын зардал	999,392.40	1,776,183.70
2105	Нормативд зардал	397.8	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,599.40	39,446.20
2107	Томиллот, зочны зардал	12,956.90	20,985.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,384.20	53,340.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,734.90	684,920.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	391	56,544.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	414,277.30	1,262,212.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	414,277.30	1,262,212.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,027,797.20	5,027,797.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,027,797.20	5,027,797.20
9	Тайлант үеийн үр дүн	414,277.30	414,277.30
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,442,074.50	5,442,074.50
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,442,074.50	5,442,074.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,442,074.50	5,442,074.50
19	Тайлант үеийн үр дүн	1,262,212.00	1,262,212.00
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,704,286.50	6,704,286.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,528,294.40	4,083,190.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	419,924.50	779,910.90
110	Орлогын албан татвар	302,812.10	670,065.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	321,305.00	688,180.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-18,492.80	-18,114.80
113	Хөрөнгийн албан татвар	32,799.50	41,014.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	84,312.80	68,831.00

1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	17,899.40	19,119.60
1181	Газрын төлбөр	10,315.10	2,526.80
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	56,098.40	47,184.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,468.20	115,427.20
120	Нийтлэг татварын бус орлого	114,468.20	115,427.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,993,901.80	3,187,852.70
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,293,944.40	2,259,464.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,293,944.40	2,259,464.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,291,726.40	2,200,938.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	479,799.30	765,059.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,182.30	97,299.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,172.10	655,989.90
2104	Хангамж, бараа материалын зардал	51,864.00	165,995.50
2105	Нормативд зардал	503.9	553.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,183.00	99,305.90
2107	Томилот, зочны зардал	12,956.90	20,985.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	554,957.40	137,104.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,107.50	258,644.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,218.00	58,525.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,234,350.00	1,823,726.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,131,822.20	1,679,999.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,131,822.20	1,679,999.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,131,822.20	1,679,999.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,131,822.20	-1,679,999.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-36,000.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	36,000.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	66,527.80	143,727.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	471,714.20	538,242.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	538,242.10	681,969.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,908,762.90	3,420,521.82
УРСГАЛ ЗАРДАЛ	1,798,600.00	1,740,522.80

БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,740,074.50	1,681,997.30
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	775,897.30	764,399.10
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,987.20	97,217.30
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	684,136.60	654,989.90
Хангамж, бараа материалын зардал	37,753.10	37,690.80
Нормативт зардал	553.7	553.7
Эд хогшил, урсгал засварын зардал	10,634.90	10,434.00
Томилолт, зочны зардал	20,985.20	20,985.20
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,087.60	40,356.80
Бараа үйлчилгээний бусад зардал	64,038.90	55,370.60
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,525.50	58,525.50
Бусад урсгал шилжүүлэг	58,525.50	58,525.50
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,075,079.50	1,679,999.00
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35,083.40	0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,908,762.90	3,380,763.57
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,195,015.60	3,271,454.59
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	713,747.30	109,308.98
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	371,238.95
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	331,480.70
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	9	9
АЖИЛЛАГСДЫН ТОО	0	0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0	0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	158,014.08	644,265.30
УРСГАЛ ЗАРДАЛ	158,014.08	644,265.30
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,169.08	518,941.50
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,173.23	660
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	602.5	82.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	343.78	1,000.00
Хангамж, бараа материалын зардал	11,615.39	128,304.80
Эд хогшил, урсгал засварын зардал	2,228.68	88,871.90

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,058.23	96,748.00
Бараа үйлчилгээний бусад зардал	83,120.83	203,274.30
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,026.43	125,323.80
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,845	125,323.80
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	158,014.08	644,265.30
Нэмэлт санхүүжилтийн орлого	158,014.08	644,265.30

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар ОНХС-тай холбоотой нийт 472,638.5 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс аудитын явцад 5,342.7 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- ОНХС-гийн авлагыг 5,342.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Залруулагдаагүй нийт 467,295.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалтай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 467,295.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 19,204.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бичигдэж 448,091.6 мянган төгрөгийн 4 заалт бүхий зөвлөмж бичлээ.

3.1 Төлбөрийн акт:

3.1.1 Илрүүлэлт: ОНХС-ийн ажлын захиалагчийн хяналтын зардлыг суутган аваагүй 19,204.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6. “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

3.2. Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Орон нутаг хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-аар хөрөнгөөр хийгдсэн ажлуудад 2022-2023 онуудад 248,629.9 мянган төгрөгийн санхүүжилт олгоод авлагаар бүртгэсэн ч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, хяналтыг хэрэгжүүлээгүй 2024 онд тус ажлууд нь огт хэрэгжээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүргийг хүлээнэ”, 20,2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ОНХС-гийн авлагыг харилцагч байгууллага бүрээр гарган тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, гэрээний хугацаа дууссан аж ахуйн нэгжүүдээс олгосон санхүүжилтийг буцаан нэхэмжлэн авах.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээнд иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг баталж 64,875.8 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардал санхүүжүүлсэн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлж урсгал зардал санхүүжүүлэхгүй байх.

3.2.3 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Босго үнээс давсан ажлуудыг задалж худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр 134,586.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж ажил гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлуулах саналыг сумын ИТХ-д оруулахдаа зориулалт болон хүчин чадал, нэршил, байршил нь ижил арга хэмжээг нийт дүнгээр нь батлуулан хуулийн хүрээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

3.2.4 Цалингийн бүртгэл

Илрүүлэлт: Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нь орон нутгийн нэмэгдлийг 80 хувиар авч бусад төрийн албан хаагчид нь 50 хувиар авч байгаа нь Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтын 2.3-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны, үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно", 2.5-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ИТХ болон ЗДТГ-ын ажилчдын орон нутгийн нэмэгдлийг жил түвшинд болгож 1 ажилтанд давуу байдал үүсгэдэг байдлыг таслан зогсоох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 07 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ОНХС	Авлагыг санхүүгийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн	1	42,111.5	1	42,111.5			1	42,111.5				
	Үр дүнгийн тайланд орлогыг зөрүүтэй илэрхийлсэн	1	354.8			1	354.8	1	354.8				
ХХС	Авлагыг санхүүгийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн	1	6,579.7			1	6,579.7	1	6,579.7				
	Үр дүнгийн тайланд орлогыг зөрүүтэй илэрхийлсэн	1	5,209.1			1	5,209.1	1	5,209.1				
ДҮН		4	54,255.1	1	42,111.5	3	12,143.6	4	54,255.1	0	0	0	0

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ОНХС	Авлагын эхний үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	200,461.1					1	200,461.1		

A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		